



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Төлбөртэй болон нэмэлт тусламж  
үйлчилгээний журам, жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Жагсаалт, журам батлах тухай" А/117 тоот тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" 49/А/118 дугаар тушаал, амаржих газрын дүрмийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нэмэлт болон төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг"-г нэгдүгээр, "Төлбөрт тусламж үйлчилгээний төлбөрийг хураах, төвлөрүүлэх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл даатгуулагч өөрөө төлөх төлбөрийн хэмжээ төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний жагсаалтыг байгууллагын цахим хуудас үйлчилгээний танхимуудад үйлчлүүлэгчид харагдахуйц газар ил тод байршуулан олон нийтэд сурталчилах, үйлчилгээний үнэ тарифийг үйлчлүүлэгчидэд танилцуулахыг эмэгтэйчүүдийн эмгэгийг судлах тасгийн эрхлэгч, Амбулаторийн тасгийн эрхлэгч, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч, ахлах эх баригч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журамд заасан үнийн тарифийн дагуу санхүүгийн хяналт тавьж улирал бүр орлогын дүн, зарцуулалтын мэдээллийг удирдлагад танилцуулан, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Дангаа/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /С.Ганболд/-д даалгасугай.

5. Төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн орлого зарлагын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналтын ажилтан /Ө.Сүрнээ/-д даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Амаржих газрын даргын 2019 оны А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Ц.БАТБОЛД

1.26	Биохимийн шинжилгээ	Триглицерид	3,000
1.27	Биохимийн шинжилгээ	Холестерин	3,000
1.28	Биохимийн шинжилгээ	Шүлтлэг фосфотаза	4,000
1.29	Биохимийн шинжилгээ	Шээсний хүчил (цус)	3,000
1.30	Гематологийн шинжилгээ	УЭТХ (СОЭ)	4,500
1.31	Гематологийн шинжилгээ	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	14,000
1.32	Иммуногематологийн шинжилгээ	anti-A титр	27,000
1.33	Иммуногематологийн шинжилгээ	anti-B титр	27,000
1.34	Иммуногематологийн шинжилгээ	anti-D титр	18,000
1.35	Иммуногематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	11,000
1.36	Иммуногематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо тодорхойлох	15,000
1.37	Иммунологийн шинжилгээ	Бүдүүн гэдэсний СЕА	22,000
1.38	Иммунологийн шинжилгээ	ДОХ (HIV cassette)	6,000
1.39	Иммунологийн шинжилгээ	Ийлдэсний С урвалжийн уураг (CRP) цус наалдуулах арга	11,000
1.40	Иммунологийн шинжилгээ	Өндгөвчний хавдрын маркер –CA 125-II	25,000
1.41	Иммунологийн шинжилгээ	Өтгөнд хеликобактер тодорхойлох	20,000
1.42	Иммунологийн шинжилгээ	Прогестерон (Progesteron)	23,000
1.43	Иммунологийн шинжилгээ	Прокалцитонин (Procalcitonin)	85,000
1.44	Иммунологийн шинжилгээ	Пролактин (Prolactin)	23,000
1.45	Иммунологийн шинжилгээ	Тестостерон (Testosteron)	24,000
1.46	Иммунологийн шинжилгээ	Тиреод сэдээгч даавар (TSH)	17,000
1.47	Иммунологийн шинжилгээ	Тироксин даавар (Т4)	17,000
1.48	Иммунологийн шинжилгээ	Токсоплазм вирусын архаг халдвар (Тохо IgG) электрохимолюминесценц	22,000
1.49	Иммунологийн шинжилгээ	Токсоплазм вирусын архаг халдвар (Тохо IgM) электрохимолюминесценц	22,000
1.50	Иммунологийн шинжилгээ	Триодтиронин даавар (Т3)	15,000
1.51	Иммунологийн шинжилгээ	Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил (ТРНА)	5,000
1.52	Иммунологийн шинжилгээ	Улаанууд вирусийн архаг халдвар (Rubella IgG) электрохимолюминесценц	23,000
1.53	Иммунологийн шинжилгээ	Улаанууд вирусийн хурц халдвар (Rubella IgM) электрохимолюминесценц	23,000
1.54	Иммунологийн шинжилгээ	Хепатитын С вирусийн эсрэг бие (anti-HCV) cassette	6,000

Амгалан амаржих газрын Захирлын  
2022 оны 15 дугаар сарын 15-ны өдрийн  
15/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



А.ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ,  
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Даатгалгүй иргэн өөрийн хүсэлтээр лабораторийн шинжилгээ/оношилгооны ажилбар, хэмжилт сорил, шинжилгээ хийлгэх төлбөрийн төрөл, үнэ			
№	Тусламж үйлчилгээний төрөл		Үнэ тариф /төг/
1.1	Бичил амь судлалын шинжилгээ	Мөөгөнцөр илрүүлэх	28,000
1.2	Бичил амь судлалын шинжилгээ	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, шээсний сүв, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цөс))	32,000
1.3	Бичил амь судлалын шинжилгээ	Нян тээгчийн шинжилгээ	30,000
1.4	Бичил амь судлалын шинжилгээ	Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх – Граммын будгийн арга	10,000
1.5	Бичил амь судлалын шинжилгээ	Цуснаас бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ	72,000
1.6	Биохимийн шинжилгээ	АЛАТ	3,000
1.7	Биохимийн шинжилгээ	Альбумин	3,000
1.8	Биохимийн шинжилгээ	Амилаза	5,000
1.9	Биохимийн шинжилгээ	Антистрептолизин О тэст (ASLO / ASO) – тоогоор	10,000
1.10	Биохимийн шинжилгээ	АСАТ	3,000
1.11	Биохимийн шинжилгээ	Билирубин нийт	3,000
1.12	Биохимийн шинжилгээ	Билирубин шууд	3,000
1.13	Биохимийн шинжилгээ	Билирубин шууд бус	3,000
1.14	Биохимийн шинжилгээ	Глутамат дегидрогеназа-GLDH (Glutamate dehydrogenase)	5,000
1.15	Биохимийн шинжилгээ	Глюкоз	3,000
1.16	Биохимийн шинжилгээ	Кали	5,000
1.17	Биохимийн шинжилгээ	Кальци	4,000
1.18	Биохимийн шинжилгээ	Креатинин	4,000
1.19	Биохимийн шинжилгээ	Лактат	5,000
1.20	Биохимийн шинжилгээ	ЛДГ	4,000
1.21	Биохимийн шинжилгээ	Магни	4,000
1.22	Биохимийн шинжилгээ	Мочевин	4,000
1.23	Биохимийн шинжилгээ	Нийт уураг	3,000
1.24	Биохимийн шинжилгээ	Ревматоид фактор /RF (тоогоор)	9,000
1.25	Биохимийн шинжилгээ	С урвалжийн уураг (CRP) (тоогоор)	11,000

1.55	Иммунологийн шинжилгээ	Хөхний хавдрын маркер (CA 15-3)	35,000
1.56	Иммунологийн шинжилгээ	Хурдавчилсан ийлдсийн реакен тест (RPR)	8,000
1.57	Иммунологийн шинжилгээ	Хүний хорион гонадотропины даавар (HCG+b II)	22,000
1.58	Иммунологийн шинжилгээ	Цитомегаловирус капсид уургийн эсрэг IgG электрохимолюминесценц	30,000
1.59	Иммунологийн шинжилгээ	Цитомегаловирус капсид уургийн эсрэг IgM электрохимолюминесценц	30,000
1.60	Иммунологийн шинжилгээ	Чөлөөт Тироксин даавар (FT4)	15,000
1.61	Иммунологийн шинжилгээ	Чөлөөт Триодтиронин даавар (FT3)	20,000
1.62	Иммунологийн шинжилгээ	Элэгний хавдрын маркер (AFP)	20,000
1.63	Иммунологийн шинжилгээ	Эстрадио (Estradio)	21,000
1.64	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	АРТТ	5,000
1.65	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	D-Dimer	60,000
1.66	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Fibrinogen	6,000
1.67	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	ТТ	5,000
1.68	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	PT (INR)	5,000
1.69	Шимэгч судлалын шинжилгээ	Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /натив харах	5,000
1.70	Эд эсийн шинжилгээ	Цитологи шинжилгээ	10,000
1.71	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Үтрээний наалдцын шинжилгээ	13,000
1.72	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Хоногийн /шээс/ уураг тодорхойлох	6,000
1.73	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Хоногийн шээсэнд сахар үзэх	6,000
1.74	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Цусны хийн шинжилгээ	28,000
1.75	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Шээсний ерөнхий шинжилгээ	6,000
1.76	Молекул генетикийн шинжилгээ	Пренатал илрүүлэг (Хоёрол тест)	120,000
2.	Даатгалгүй иргэн өөрийн хүсэлтээр Амбулаторийн тусламж, үйлчилгээ хийлгэх төлбөрийн хэмжээ, төрөл		
2.1	Үргүйдлийн тусламж үйлчилгээ		
2.1.1	Үргүйдлийн эмгэгийн үзлэг,	Бэлгийн эс, төмсөг, өндгөвчний эд хөлдөөх	450,000
2.1.2		Өндгөн эс соруулах ажилбар	1,700,000

2.1.3	оношилгоо, эмчилгээ, хяналт	Үр хөврөл өсгөвөрлөх ажилбар	1,500,000	
2.1.4		Үр хөврөлийг умайн хөндийд шилжүүлэн суулгах ажилбар	470,000	
2.1.5		Хөлдөөсөн үр хөврөлийг гэсгээж умайн хөндийд шилжүүлэн суулгах ажилбар	680,000	
2.1.6		Өндгөн эсийн цитоплазмд эр бэлгийн эсийг тарьж үр тогтоох ажилбар	380,000	
2.1.7		Эр бэлгийн эсийг угааж умайн хөндийд цацах ажилбар	375,000	
2.1.8		Өндгөвчийг зөөлөн сэдээх протокол эмчилгээ/эстрогены рецепторт хориг үүсгэгч эм эсвэл ароматаза ингибитор эм, гонадотропин даавар, гонадотропины антагонист, хорионы гонадотропин даавар	1,650,000	
2.1.9		Гонадотропины антагонист протокол эмчилгээ /гонадотропин даавар, гонадотропины антагонист тариа, хорионы гонадотропин	3,400,000	
2.1.10		Үрийн шингэний дэлгэрэнгүй шинжилгээ	90,000	
2.1.11		Үрийн шингэний ерөнхий шинжилгээ	50,000	
2.1.12		Гонадотропины агонист урт протокол эмчилгээ /гонадотропин даавар, гонадотропины агонист тариа, хорионы гонадотропин/	4,200,000	
2.1.13		Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор төмсөгний эдийг авах /TESE/	450,000	
2.1.14		Үрийн шингэнд эр эс байхгүй үед төмсгөнд оношилгоо эмчилгээний зорилгоор хатгалт хийх /PESA/	350,000	
2.2		Амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээ		
2.2.1		Үзлэг /ажлын бус цагаар/	Гавьяат эмч, АУ-н доктор, зөвлөх эмчийн үзлэг	35,000
2.2.2	Тэргүүлэх зэрэгтэй клиникийн профессор эмчийн үзлэг		20,000-30,000	
2.2.3	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Ургийн зүрхний цахилгаан бичлэг	30,000	
2.2.4		Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг	30,000	
2.2.5		Зүрхний цахилгаан бичлэг	9,000	
2.2.6		12 сувгын холтер зүрхний цахилгаан бичлэг	80,000	
2.2.7		7 сувгын холтер зүрхний цахилгаан бичлэг	600,000	
2.2.8		Дурангийн хэт авиан оношилгоо (EUS)	550,000	
2.2.9		Унтуулгатай уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой, ходоод, төвөнх)	100,000	
2.2.10		Хэт авиа (зүрх, бамбай булчирхай, хөх, захын судас, нүд, хэвлий, нярайн түнх, нярайн зулай, цээж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхтэн, гүрээний артери, зөөлөн эд, шөрмөс, үе, тархины судасны допплер, тархины судасны дуплекс)	15,000	
2.2.11		Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг)	10,000	

		аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	
2.2.12		Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000
2.2.13		Рентген харалт (Цээж, хэвлий)	10,000
2.2.14	Урьдчилан сэргийлэх, урт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Гэрээний үнийн дүнгээр
2.2.15		Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах	80,000
2.2.16		Гэр бүл болох, ажилд сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	80,000

#### Б. НӨХЦЛИЙН НЭМЭГДЭЛТЭЙ ӨРӨӨНИЙ ТӨЛБӨР

№	Тасгийн нэр	Орны тоо	Өрөөний тоо	Үнийн тариф
1	Төрсний дараах тасаг	200	7	60 000
2	Жирэмсний эмгэгийг эмчлэх тасаг		2	60 000
3	Эмэгтэйчүүдийн тасаг		2	60 000
4	Эрчимт эмчилгээний тасаг		3	
5	(Vip) бэлдсэн төрөх өрөөнд		3	60 000
6	Нярайн тасаг		1	

#### В. ҮР ХӨНДӨЛТИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ:

1. Эрт үеийн үр хөндөлт
2. Иргэн санаатайгаар амь насаа бусниулахаар оролдсон тохиолдолд тусламж үйлчилгээ, оношлогоо, эмчилгээ хийх

#### Төлбөрийн жагсаалт


№	Заалт	Төлбөр /төгрөгөөр/
1.	Жирэмсэний эрт үеийн үр хөндөлт /12 долоо хоног хүртэл, унтуулагагүй/	75,000
2.	Иргэн санаатайгаар амь насаа бусниулахаар оролдсон тохиолдлын тусламж, үйлчилгээ оношлогоо эмчилгээ / кремнал/1 хоног	Бодит зардлаар
3.	Жирэмсний эрт үеийн эмийн үр хөндөлт /12 долоо хоног хүртэл /	50,000
4.	Жирэмсний эрт үеийн үр хөндөлтийг /12 долоон хоног хүртэл унтуулгатай /	95000

**С. БУСАД НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Тусламж үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Төлбөрийн жишиг хэмжээ
1.	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээний (люкс)	60,000
2.	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээний (хагас люкс)	30,000
3.	Захиалгат ариутгал	Бикс, боодол (том, дунд, жижиг)	15,000

\*Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлүүлэх (төрөх, төрсний дараах, ЖЭЭТ, эмэгтэйчүүд, нярай) тасагт хэвтэж, амбулаторийн тусламж үйлчилгээ (өдрийн эмчилгээ, мэс ажилбар, эмчилгээ)-г авсан даатгалгүй үйлчлүүлэгчид ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны 01 дугаартай “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу тухайн оношийн бүлгээрээ төлбөрөө 100% өөрөө хариуцан төлнө.

Амгалан амаржих газрын Захирлын  
2022 оны 05 дугаар сарын 02 -ны өдрийн  
А/У дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ТӨЛБӨРТ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг /Амгалан амаржих газар ТМЭ гэх/-ээс үзүүлэх улсын төсвөөс хариуцах болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөртэй тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн хэмжээ, жагсаалтад заасан хэмжээнээс хэвтрүүлэхгүй, код, ангиллыг өөрчлөхгүйгээр батална.
- 1.4 Гадаадын иргэнд Олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл даатгуулагч өөрөө төлөх төлбөрийн хэмжээ төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний жагсаалтыг байгууллагын цахим хуудас үйлчилгээний танхимуудад үйлчлүүлэгчид харагдахуйц газар ил тод байршуулан олон нийтэд сурталчилах, үйлчилгээний үнэ тарифийг үйлчлүүлэгчидэд танилцуулахыг эмэгтэйчүүдийн эмгэгийг судлах тасгийн эрхлэгч, Амбулаторийн тасгийн эрхлэгч, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч, ахлах эх баригч нар хариуцан ажиллана.
- 2.2 Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журамд заасан үнийн тарифийн дагуу санхүүгийн хяналт тавьж улирал бүр орлогын дүн, зарцуулалтын мэдээллийг удирдлагад танилцуулан, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүүгийн алба хариуцан зохион байгуулна.
- 2.3 Иргэнд төлбөр төлсөн баримт, "E-Barimt"-ыг заавал олгох бөгөөд төвийн нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөр зохих нийт болон



үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

- 2.4 Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлдэг тасаг, нэгжид төлбөрийн тооцооны зөрчлийн эрсдлээс хамгаалах санамж бичгийг заавал байрлуулна.
- 2.5 Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож баримтжуулна.

Гурав. Нөхцөл сайжруулсан төлбөртэй өрөө ажиллуулах

- 3.1 Төлбөрт өрөөний тоо нь төвийн батлагдсан нийт орны 10%-ас илүүгүй байна.
- 3.2 Төлбөртэй орны төлбөрийг кассанд тушаасан байна.
- 3.3 Эмнэлгийн дотоод журмыг зөрчсөн эмчлүүлэгчдэд төлбөрийг буцаан олгохгүй.
- 3.4 Төлбөртэй өрөөнд хэвтсэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

Дөрөв. Урьдчилан сэргийлэг үзлэг, бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

- 4.1 Урьдчилсан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах аж ахуйн нэгж байгууллага нь захиалгаа өгч, гэрээ байгуулж, баталсан хуваарийн дагуу үзлэг, тусламж, үйлчилгээ хийлгэнэ.
- 4.2 Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах хувь хүн сонгосон багцын төлбөрийг тушаан үзлэг, тусламж, үйлчилгээ хийлгэнэ.

Тав. Хориглох зүйл

- 5.1 “Эрүүл мэндийн тухай” хуулийн 24.6 дугаар зүйлд заасан тусламж, үйлчилгээ буюу “Төлбөрийг нь төр хариуцах тусламж үйлчилгээг”-г авч буй иргэнээс төлбөр авах.
- 5.2 ЭМД-ын сангаас оношилгоо, шинжилгээнд олгож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авахыг хориглоно.
- 5.3 Үйлчлүүлэгчдээс жагсаалтанд зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, эмч, мэргэжилтнүүд иргэдтэй шууд төлбөр тооцоо хийх.
- 5.4 “Эрүүл мэндийн тухай” хуулийн 28.1.1 ба 28.1.4-д заасан эмнэлгийн яаралтай, түргэн тусламж, гэнэтийн осоол болон эрчимт эмчилгээний үед хийгдэх эмчилгээ, үйлчилгээг төлбөртэй хийх.
- 5.5 Ажлайн байрандаа эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, биологийн идэвхт бодис худалдаалах.
- 5.6 Иргэдээс нөмрөг, улавч, бие засах газар, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авах.

Зургаа. Хяналт үнэлгээ

- 6.1 Төлбөрт тусламж, үйлчилгээ нь төвийн үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, эмнэлгийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх шаардлагыг харгалзан нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийн эмнэлгийн Захирал хүлээнэ.

- 6.2 Төлбөртэй үйлчилгээний орлого, зарцуулалтын үнэлгээний дотоотдын хяналт шинжилгээг Дотоод хяналтын ажилтан улирал бүр хийнэ.
- 6.3 Төлбөрт тусламж, үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн болон орлого зарцуулалтын тухай мэдээллийг нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах үүргийг холбогдох албан тушаалтнууд хүлээнэ.

Долоо. Журам зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

- 7.1 Энэхүү журам зөрчсөн албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хөдөлмөрийн тухай хууль, эмнэлгийн дотоод журамд заасан арга хэмжээг авч, хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.
- 7.2 Хэрэв эмнэлгийн Захирлын эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэх боломжгүй тохиолдолд холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

Боловсруулсан  
Хянасан  
Хүр  
Огноо